



СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД ОРОЛЦОХ УРИЛГА

2025 оны 07 сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө”-нд орсон дараах ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтын нэр: Газар тариалангийн салбарын ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах

Ажлын даалгавар татаж авах холбоос: <https://publuu.com/flip-book/938033/2058140>

Төсөвт өртөг: 8 000 000 төгрөг

Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн эрх бүхий оролцогч нь энэхүү урилгад заасан холбогдох хаягаар Захиалагчаас ажлын өдрүүдэд 08:00-16:00 цагийн хооронд нэмэлт мэдээлэл авч болно.

Сонгон шалгаруулалтад ирүүлэх саналаа 2025 оны 07 дугаар сарын 31-нээс 08 дугаар сарын 06-ны өдрийн 17:00 цагт эсхүл түүнээс өмнө урилгад заасан хаягаар ирүүлнэ. Хугацаа хоцорсон саналыг хүлээн авахаас татгалзана.

Сонирхсон оролцогч нь Захиалагчид бичгээр Монгол хэл дээр бэлтгэгдсэн Сонгон шалгаруулалтын баримт бичгийг битүүмжлэн цаасаар 2% (хоёр хувь) болон pdf өргөтгөлтэй файл хэлбэрээр ирүүлнэ үү.

Санал хүлээн авах хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Хөдөлмөрийн ордон, 4-н давхар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн 407 тоот

Холбоо барих утас, цахим шуудангийн хаяг: 7715-4949, 7712-4949, Bnarantsetseg@osh.gov.mn

Санал бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор сонгон шалгаруулалтад оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Захиалагч хариуцахгүй.

Цахим шуудангаар илгээсэн баримт бичиг, тодруулга хугацаа хоцорч хүргээгдсэнтэй холбоотойгоор Захиалагч ямар нэг хариуцлага хүлээхгүй.